


ECR-R асуулгын Монгол хувилбар: Оюутнуудын түүвэр дэх сэтгэц хэмжил зүйн шинжилгээ

Насанбат Номинзул
Шинжлэх Ухааны Академи, Тархи, Сэтгэл Судлалын Хүрээлэн

Цэнд Баярмаа
Монгол Улсын Боловсролын Их Сургууль

https://journal.mnier.mn

Санал болгож буй эшлэл:
Номинзул, Н., & Баярмаа, Ц. (2026). ECR-R асуулгын Монгол хувилбар: Оюутнуудын түүвэр дэх сэтгэц хэмжил зүйн шинжилгээ. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, *31(1)*. https://doi.org/10.56380/mjer.v31.1.7

The Mongolian Version of the ECR-R: A Psychometric Evaluation in a University Student Sample

Nominzul Nasanbat
Institute of Neuroscience and Psychology, Mongolian Academy of Sciences

Bayarmaa Tsend
Mongolian National University of Education

To cite this article:
Nominzul, N., Bayarmaa, Ts. (2026). The Mongolian Version of the ECR-R: A Psychometric Evaluation in a University Student Sample. *Mongolian Journal of Educational Research*, *31(1).* https://doi.org/10.56380/mjer.v31.1.7

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.

This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Боловсролын судалгааны Монголын сэтгүүл MJER

2026, Vol.31, No.1 https://doi.org/10.56380/mjer.v31.1.7

ECR-R асуулгын Монгол хувилбар: Оюутнуудын түүвэр дэх сэтгэц хэмжил зүйн шинжилгээ

Насанбатын Номинзул, Цэндийн Баярмаа

Өгүүллийн мэдээлэл

Түүх:
Хүлээн авсан: 2026.06.18
Засаж сайжруулсан: 2026.11.09
Хэвлэхийг зөвшөөрсөн: 2026.11.11

Түлхүүр үг:
баталгаат чанар
тохироц чанар
хүчин зүйлийн шинжилгээ
монгол
оюутнууд

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны зорилго нь насанд хүрэгчдийн ойр дотно харилцаанд илрэх ээнэгшлийн хэв маягийг үнэлэх Experiences in Close Relationships-Revised (ECR-R) арга зүйн монгол хувилбарын баталгаат болон тохирц чанарын үзүүлэлтүүдийг тогтооход оршино. Улаанбаатар хотын дөрвөн их, дээд сургуулийн 18-36 насны 551 оюутан (эрэгтэй 18.5 хувь, эмэгтэй 81.5 хувь; дундаж нас 20.6) судалгаанд сайн дурын үндсэн дээр оролцсон. 14 хоногийн дараа тест ре-тест судалгаанд 359 оролцогч дахин хамрагдсан. Дотоод нийцлийн Кронбах альфа коэффициент нийт түүвэрт α=.950, "түгшүүр" дэд хэмжүүрийн хувьд α=.900, "зайлсхийх" дэд хэмжүүрийн хувьд α=.891 байсан бол тест ре-тест тогтвортой байдлын ICC нь тус тус .946 ба .928 байв. Агуулгын тохирц чанарын индекс CVI=0.88 байна. Варимакс эргэлттэй хайгуулын хүчин зүйлийн шинжилгээ (EFA)-ээр гурван хүчин зүйлт бүтэц илэрч, зарим батламж (A9r, A11r, A16, A21) хангалттай ачааллаагүй. Баталгаажуулах хүчин зүйлийн шинжилгээ (CFA)-ий эцсийн загвар нь CFI=0.816, TLI=0.800, RMSEA=0.086, SRMR=0.078 гэсэн үзүүлэлттэй гарч, таамагласан хоёр хэмжээст бүтцийг бүрэн дэмжээгүй тул Монгол орчуулгын хувилбарт тохиромжтой загварыг цаашид нарийвчлан тогтоох шаардлагатайг үр дүн харуулж байна.

Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial ShareAlike 4.0 Олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:
Ц.Баярмаа
Сэтгэл судлалын тэнхим, Боловсрол судлалын сургууль, Монгол Улсын Боловсролын Их Сургууль
Email: ts.bayarmaa@msue.edu.mn

The Mongolian Version of the ECR-R: A Psychometric Evaluation in a University Student Sample

Nominzul Nasanbat, Bayarmaa Tsend

Article information

Article history:
Received: Jun 18, 2026
Revised: Nov 09, 2026
Accepted: Nov 11, 2026

Keywords:
reliability
validity
factor analysis
Mongolia
university students

ABSTRACT

This study examined the psychometric properties of the Mongolian version of the Experiences in Close Relationships-Revised (ECR-R), which assesses adult attachment anxiety and avoidance. A total of 551 university students (aged 18-36; 81.5% female; *M* = 20.6, *SD* = 2.64) from four universities in Ulaanbaatar participated voluntarily, and 359 completed a 14-day retest. The questionnaire was translated into Mongolian following international guidelines, including forward and back translation. Internal consistency was excellent (Cronbach's α = .950 for the total scale, .900 for Anxiety, .891 for Avoidance), as was test–retest reliability (ICC = .946 and .928, respectively). The scale-level content validity index was 0.88. Exploratory factor analysis yielded a three-factor structure, and items A9r, A11r, A16, and A21 did not load adequately. In confirmatory factor analysis, the best-fitting 24-item model showed unsatisfactory fit (CFI = 0.816, TLI = 0.800, RMSEA = 0.086, SRMR = 0.078), so the hypothesized two-dimensional structure was not fully supported. The Mongolian ECR-R demonstrates high reliability and acceptable content validity, but its factor structure requires further refinement, including bifactor and culturally adapted models, in more diverse samples.

This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:
Bayarmaa.Ts
Department of Psychology, School of Educational Studies, Mongolian National University of Education
Email: ts.bayarmaa@msue.edu.mn

УДИРТГАЛ

Хүүхэд төрсөн цагаасаа эхлэн эх, эцэг болон бусад асран хамгаалагчийн тусламжтайгаар гадаад ертөнцтэй харилцаж эхэлдэг. Эхний жилүүдийн харилцааны туршлага нь хүүхдийн цаашдын нийгмийн харилцааны хэв маягийг бүрдүүлэхэд ихээхэн нөлөөлдөг (Jones et al., 2015).

Ээнэгшихүйн онолыг Боулби (1979) бага насны хүүхэд асран хамгаалагчаасаа салсан үед илэрдэг хүчтэй түгшүүр, айдас болон ойр дотно байдлыг эрэх зан үйлийг ойлгох зорилгоор дэвшүүлсэн. Тэрбээр ээнэгшихүйн зан үйлийг биологийн суурьтай сэдлийн тогтолцоо хэмээн тодорхойлсон бөгөөд энэхүү тогтолцоо бага наснаас насан туршид оршин тогтнодог гэж үзжээ (Bretherton, 1985).

Хазан болон Шавер (1987) нар Боулбигийн онолыг насанд хүрэгчдийн романтик харилцааны хүрээнд системтэйгээр хэрэглэж, хайр дурлалыг ээнэгшихүйн үйл явцын нэг хэлбэр гэж тайлбарласан. Тэдний дүгнэснээр насанд хүрэгчдийн ойр дотно харилцааны ялгааг тайлбарлахад түгшүүртэй болон зайлсхийсэн гэсэн хоёр үндсэн хэмжээс хангалттай болохыг Бреннан нар (1998) эмпирик аргаар баталсан. Энэ хоёр хэмжээст загварт суурилан Фрейли нар (2000) ECR-R асуулгыг боловсруулсан нь орчин үеийн судалгаанд хамгийн өргөн хэрэглэгддэг хэрэгсэл болжээ. Гэсэн хэдий ч ээнэгшихүйн хэв маяг нь соёл, хэл, гэр бүлийн харилцааны хэв маягтай нягт уялдаатай тул нэг хэл, соёлын орчинд боловсруулагдсан арга зүйг шууд өөр орчинд хэрэглэх нь хязгаарлагдмал байж болно (Alonso-Arbiol et al., 2008).

Иймд ECR-R-ийн монгол хэлний хувилбарын сэтгэц хэмжил зүйн үзүүлэлтүүдийг бие даасан түүвэр дээр тогтоох шаардлагатай байна.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Равиц нарын (2010) хорин таван жилийн тойм судалгаагаар насанд хүрэгчдийн ээнэгшлийн хэв маягийг үнэлэх 29 арга зүй сэтгэц хэмжил зүйн шаардлагыг хангасан нь тогтоогдсон бөгөөд тэдгээрийн дотроос *ECR-R* нь хамгийн өргөн хэрэглэгддэг арга зүй хэвээр байна. ECR-R нь өөрийгөө үнэлэх ээнэгшлийн 60 хэмжүүрийн 323 батламжаас гол компонентийн шинжилгээгээр гаргасан 36 батламж (item) бүхий асуулга юм (Brennan et al., 1998; Fraley et al., 2000).

18 батламж нь “түгшүүртэй ээнэгшил”-ийн, үлдсэн 18 нь “зайлсхийсэн ээнэгшил”-ийн хэмжээсийг үнэлдэг. Судлуулагч батламж бүрийг 1 (огт санал нийлэхгүй)-ээс 7 (бүрэн санал нийлж байна)-ын хооронд дүгнэнэ.

ECR-R нь 20 гаруй хэл дээр орчуулагдсан байна. Хинди хувилбарын судалгаагаар (Kumar, 2022) хоёр хэмжээст загвар дэмжигдсэн (CFI=0.90, RMSEA=0.05). Унгар хувилбар (Dupont et al., 2022) үндэсний хэмжээний N=958 түүвэр дээр хоёр хэмжээст загварыг баталсан (CFI=0.921, RMSEA=0.052). Урду хувилбар (Hayee & Kamal, 2023) хүчин зүйлийн ачаалал бага батламжуудыг хасаж 26 батламжийн загварыг санал болгосон. Харин Итали (Busonera et al., 2014) болон Голланд (Kooiman et al., 2012) хувилбаруудын CFA-д таамагласан хоёр хэмжээст бүтэц хангалттай тохиролтой гараагүй байна.


Монголд сүүлийн жилүүдэд гадны арга зүйг орчуулж, сэтгэц хэмжил зүйн үзүүлэлтийг тооцсон судалгаанууд нэмэгдэж байгаа бөгөөд ECR-ийн хүүхдийн хувилбар (ECR-RC)-ыг орчуулан 434 дунд сургуулийн сурагч дээр шалгасан (баталгаат чанарын шинжилгээнд 427, хоёр долоо хоногийн дараах ре-тестэд 374 сурагч хамрагдсан). Анхны 36 батламжаас 24-ийг (түгшүүрийн 11, зайлсхийхийн 13) үлдээсэн эцсийн загвар нь эцэг, эхийн аль аль хэлбэрт хоёр хүчин зүйлт бүтцийн хувьд хүлээн зөвшөөрөгдөхүйц тохирсон байна (Tsend et al., 2026). Ойр дотно харилцаа, сэтгэл хөдлөлийн байдалтай холбоотой бусад хэмжүүрээс Хүрэлттэй холбоотой туршлага, хандлагын асуулга (TEAQ)-ыг 18-57 насны 204 оролцогч дээр шалгахад 55 батламжтай зургаан бүрэлдэхүүнт бүтэц гарч, зарим дэд хэмжүүр түгшүүр, сэтгэл гутралтай сөрөг хамааралтай байсан (Tumurbaatar et al., 2022). Мөн Эмнэлгийн түгшүүр, сэтгэл гутралын асуулга (HADS) нь 1094 хүний түүвэр дээр нийт хэмжүүрийн хувьд хүлээн зөвшөөрөгдөхүйц дотоод нийцэлтэй (α=.776) бөгөөд ре-тестийн ICC=.872 байсан (Tumurbaatar et al., 2021). Амьдралын чанарын богино асуулга (WHOQOL-BREF)-ын Монгол хувилбар нь 301 насанд хүрэгч дээр найдвартай, хүчин төгөлдөр гэж дүгнэгдсэн (Bat-Erdene et al., 2023).

Эдгээр хэмжүүр нь ECR-R-ийн нийлэх болон ялгах хүчин төгөлдөр байдлыг цаашид шалгахад ашиглагдах боломжтой. Харин насанд хүрэгчдэд зориулсан ээнэгшлийн асуулгыг Монгол хэл рүү орчуулж, баталгаажуулсан судалгаа хараахан хийгдээгүй байна.

АРГА ЗҮЙ

Орчуулгын үйл явц

Энэхүү судалгаанд ECR-R арга зүйг судалгааны зорилгоор орчуулж, судалгаанд ашиглах зөвшөөрлийг зохиогчоос авсаны дараа, англи хэлнээс монгол хэл рүү хоёр орчуулагч тусдаа орчуулсан. Үүний дараа монгол хэл рүү орчуулахад оролцоогүй сэтгэл судлаач болон хэл шинжлэлийн мэргэжилтний саналыг авч мэргэжилтнүүдийн саналд үндэслэн дахин засварласан хувилбарыг монгол хэлнээс англи хэл рүү урвуу орчуулга хийсэн. Орчуулгын явцад зарим үг хэллэгийг монгол соёлын онцлогт зохицуулан өөрчлөх шаардлага гарсан. Орчуулгын үе шатны дараа судлуулагчдад ойлгомжтой байдлыг шалгахын тулд бага хэмжээний түүвэр дээр (N=36) туршилт судалгааг зохион байгуулсан. Туршилт судалгааны дараа бид үндсэн судалгааг зохион байгуулж 14 хоногийн зайтай ре-тест судалгааг авсан.



Зураг 1. Судалгааны үйл явц

Оролцогчид

Асуулга-оролцогчийн харьцааны 10:1 зарчим болон хүчин зүйлийн шинжилгээнд тохиромжтой хэмжээг харгалзан (Bujang et al., 2024) түүврийн зорилтот хэмжээг 360-аас их байхаар тооцов. Судалгаанд Улаанбаатар хотын дөрвөн их, дээд сургуулийн 18-36 насны оюутнуудыг санамсаргүй түүврийн аргаар хамруулсан. Оролцогч бүрд судалгааны зорилго, нууцлалын нөхцөл, татгалзах эрхийг танилцуулж сайн дурын зөвшөөрлийг авав. Нийт 551 оролцогч (эрэгтэй 18.5 хувь, эмэгтэй 81.5 хувь; дундаж нас 20.6, SD=2.64) хамрагдсан бөгөөд 14 хоногийн дараа дахин оролцохыг зөвшөөрсөн 359 оролцогч ре-тест судалгаанд хамрагдав. Оролцогчдын дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл (N=551)

Шинж	Ангилал	N (хувь)
Хүйс	Эрэгтэй	102 (18.5 %)
	Эмэгтэй	449 (81.5%)
Дундаж нас (SD)	20.6 (2.64)	
Насны хүрээ	18–36	
Төрөлтийн эрэмбэ	Айлын том	218 (39.6%)

	Айлын дунд	156 (28.3%)
	Айлын бага	144 (26.1%)
	Айлын ганц	33 (6.0%)
Хосын харилцаа	Хосын харилцаагүй байгаа	282 (51.2%)
	Хосын харилцаатай байгаа	213 (38.7%)
	Огт хосын харилцаагүй	56 (10.2%)

Статистик шинжилгээ

Баталгаат чанарыг дотоод нийцлийн Кронбах альфа коэффициент (α≥0.70 хүлээн зөвшөөрөгдөх) болон тест ретест тогтвортой байдлын интракласс хамаарлын коэффициент (ICC≥0.75 хүлээн зөвшөөрөгдөх)-ээр үнэлэв.

Агуулгын тохирц чанарыг Агуулгын тохирц чанарын индекс (CVI≥0.80 хүлээн зөвшөөрөгдөх)-ээр, бүтцийн тохирц чанарыг хайгуулын (Exploratory Factor Analysis, EFA) болон баталгаажуулах (Confirmatory Factor Analysis, CFA) хүчин зүйлийн шинжилгээгээр үнэлэв. EFA-д KMO≥0.60 ба Бартлеттийн тестийн $p<0.05$ байхыг тохиромжтой гэж үзэв. CFA-д CFI≥0.90, TLI≥0.90, RMSEA≤0.08, SRMR<0.08 байхыг хүлээн зөвшөөрөгдөх тохиролтой гэж үзэв. Статистик боловсруулалтыг SPSS v.25 болон jamovi программаар гүйцэтгэв.

ҮР ДҮН

Баталгаат чанар

Нийт асуулгын Кронбах альфа коэффициент α=.950 байсан бол “түгшүүр” хэмжигдэхүүний хувьд α=.900, “зайлсхийх” хэмжигдэхүүний хувьд α=.891 байв. Тест ре-тест судалгааны ICC “түгшүүр” хэмжигдэхүүний хувьд .946 (95% CI [.938, .954], $p<.001$), «зайлсхийх» хэмжигдэхүүний хувьд .928 (95% CI [.917, .939], $p<.001$) байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Баталгаат чанарын үзүүлэлтүүд

Хэмжигдэхүүн	α (Кронбах альфа)	Батламжийн тоо	ICC	95% CI
Нийт асуулга	.950	36	—	—
Түгшүүр	.900	18	.946	[.938, .954]
Зайлсхийх	.891	18	.928	[.917, .939]

Тэмдэглэл. ICC = интракласс хамаарлын коэффициент (14 хоногийн тест ре-тест, N=359)

Агуулгын тохирц чанар

Сэтгэл судлалын салбарт мэргэшсэн, монгол болон англи хоёр хэл эзэмшсэн гурван шинжээчийн үнэлгээгээр агуулгын тохирц чанарын индекс S-CVI=0.88 гарсан нь хүлээн зөвшөөрөгдөх доод хязгаар (0.80)-аас дээш байна.

Бүтцийн тохирц чанар

Хүчин зүйлийн шинжилгээ хийхийн тулд юуны өмнө өгөгдлийн тохиромжтой байдлыг шалгахад KMO=.925 ба Бартлеттийн тест $\chi^2(630)=9177.957$, $p<.001$ гарч хүчин зүйлийн шинжилгээнд тохиромжтойг батлав. EFA хийхэд eigenvalue>1 шалгууруар таван хүчин зүйл гарч дисперсийн 54.8 хувийг тайлбарлав. Гэсэн хэдий ч хоёр дахь ба гурав дахь хүчин зүйл хоорондоо давхцаж байсан тул утгын хувьд нэгдмэл гурван хүчин зүйлт загварыг авч үзэв (Хүснэгт 3).

“Түгшүүр” хэмжигдэхүүний 9, 11, 16 дугаар батламжууд, “зайлсхийх” хэмжигдэхүүний 21 дүгээр батламжууд аль нэг хүчин зүйлд $\lambda<0.40$ гарч хангалттай ачаалаагүй. Үлдсэн батламжуудын ачаалал “түгшүүр” хүчин зүйлд .453-.747, “зайлсхийх” хүчин зүйлд .476-.792 хооронд байв.

Хүснэгт 3. Хайгуулын хүчин зүйлийн шинжилгээний ачаалал (Principal Axis Factoring, Varimax эргэлт, N=551)

Батламж	X1 (түгшүүр)	X2 (зайлсхийх)	X3	Uniqueness
A1	0.662	—	—	0.558
A2	0.718	—	—	0.473
A3	0.747	—	—	0.407
A4	0.669	—	—	0.475
A5	—	—	—	0.840
A6	0.553	—	—	0.674
A7	0.651	—	—	0.565
A8	0.692	—	—	0.469
A9r*	—	—	—	0.864
A10	0.612	—	—	0.536
A11r*	—	—	—	0.861
A12	0.542	—	—	0.537
A13	0.595	—	—	0.524
A14	0.494	—	0.436	0.558
A15	0.453	—	0.447	0.590
A16*	—	—	—	0.763
A17	0.590	—	—	0.564
A18	0.474	—	—	0.616
A19	—	—	0.446	0.751
A20r	—	0.516	—	0.727
A21*	—	—	—	0.813
A22r	—	0.541	—	0.608
A23	—	—	0.624	0.471
A24	—	—	0.665	0.492
A25	—	—	0.692	0.447
A26r	—	0.500	0.435	0.560
A27r	—	0.531	0.403	0.555
A28r	—	0.757	—	0.393
A29r	—	0.736	—	0.443
A30r	—	0.713	—	0.479
A31r	—	0.792	—	0.362
A32	—	—	0.547	0.626
A33r	—	0.696	—	0.486
A34r	—	0.476	—	0.703
A35r	—	0.539	—	0.689
A36r	—	0.689	—	0.475

Тэмдэглэл. Хоосон нүдэнд $\lambda<0.40$ байсан тул тавигдаагүй. * тэмдэгтэй батламж (A9r, A11r, A16, A21) нь аль нэг хүчин зүйлд хангалттай ачаалаагүй

EFA-аар тодорхойлогдсон бүтцийг баталгаажуулах зорилгоор гурван CFA загварыг шалгав. Хи-квадратын тест $\chi^2(593)=3066$, $p<.001$ байсан боловч том түүврийн нөлөөнд хэт мэдрэмтгий тул харьцангуй тохирцын индексүүдийг гол үзүүлэлт болгон авч үзэв.

Загвар 1 (λ>0.30 бүх батламж, n=32) нь CFI=0.719, TLI=0.702, RMSEA=0.087, SRMR=0.099 гэсэн хүлээн зөвшөөрөгдөхгүй үзүүлэлттэй гарав. Загвар 2 (λ>0.40, n=28) нь CFI=0.769, TLI=0.751 болж сайжирсан ч хангалтгүй хэвээр. Загвар 3 (λ>0.50, n=24) нь CFI=0.816, TLI=0.800, RMSEA=0.086, SRMR=0.078 гэсэн хамгийн сайн үзүүлэлттэй гарсан бөгөөд SRMR нь хүлээн зөвшөөрөгдөх хязгаарт хүрсэн ч CFI, TLI, RMSEA нь таамагласан шаардлагыг хангаагүй (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Баталгаажуулах хүчин зүйлийн шинжилгээний гурван загварын тохирц чанарын үзүүлэлтүүд

Загвар	CFI	TLI	RMSEA	SRMR	Батламжийн тоо
Зөвшөөрөгдөх утга	≥0.90	≥0.90	≤0.08	<0.08	—
Загвар 1 (λ>0.30, бүх батламж)	0.719	0.702	0.087	0.099	32
Загвар 2 (λ>0.40)	0.769	0.751	0.091	0.091	28
Загвар 3 (λ>0.50, эцсийн загвар)	0.816	0.800	0.086	0.078	24

Тэмдэглэл. Зөвшөөрөгдөх утга: CFI/TLI≥0.90; RMSEA≤0.08; SRMR<0.08. λ = хүчин зүйлийн ачааллын доод хязгаар

Монгол хувилбарын үр дүнг бусад хэлний орчуулгын CFA-тэй харьцуулахад (Хүснэгт 5) монгол загварын CFI нь Унгар (0.921) болон Урду (0.90) хувилбараас доогуур, харин Итали хувилбартай (Busonera et al., 2014) төстэй байна.

Хүснэгт 5. ECR-R-ийн хэл дамнасан CFA үзүүлэлтүүдийн харьцуулалт

Хувилбар	CFI	TLI	RMSEA	SRMR	Эх сурвалж
Монгол (Загвар 3)	0.816	0.800	0.086	0.078	Энэхүү судалгаа
Унгар	0.921	0.909	0.052	—	Dupont et al. (2022)
Урду	0.90	0.90	0.07	—	Hayee & Kamal (2023)
Хинди	0.90	0.89	0.05	—	Kumar (2022)
Итали	<0.95	<0.95	>0.05	≈0.08	Busonera et al. (2014)

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү судалгаагаар “ECR-R” асуулгын монгол хувилбарын баталгаат болон тохирц чанарын үзүүлэлтүүдийг монгол оюутнуудын түүвэр дээр судлав. Асуулгын дотоод нийцэл (α=.950) болон тест ре-тест тогтвортой байдал (ICC>.92) маш өндөр үзүүлэлттэй байсан нь Хинди (Kumar, 2022), Унгар (Dupont et al., 2022), Урду (Hayee & Kamal, 2023) хувилбаруудын баталгаат чанарын үзүүлэлттэй нийцэж байна. Агуулгын тохирц чанарын S-CVI=0.88 нь хүлээн зөвшөөрөгдөх хязгаарыг хангасан нь монгол орчуулга нь хэмжихийг зорьсон агуулгаа хангалттай тусгаж байгааг харуулна.

Харин бүтцийн тохирц чанарын хувьд EFA-аар гурван хүчин зүйлт бүтэц илэрсэн нь онолын хоёр хэмжээст загвараас ялгаатай байна. Гурав дахь хүчин зүйл нь голдуу эсрэг утгатай (reverse-worded) батламжуудыг агуулж байсан нь хэлбэржилтийн нөлөөнөөс үүдэлтэй арга зүйн хүчин зүйл байж болзошгүй юм (Kooiman et al., 2012). CFA-д эцсийн загвар (CFI=0.816, RMSEA=0.086) нь хүлээн зөвшөөрөгдөх хязгаарт хүрсэнгүй. Энэхүү дүгнэлт нь Итали (Busonera et al., 2014) болон Голланд (Kooiman et al., 2012) хувилбаруудын ижил төстэй үр дүнтэй нийцэж байна.

Монгол хэлний онцлог болон зарим батламжийн орчуулгын найруулга нь хэмжилтийн тохирцод нөлөөлсөн байж болзошгүй. Тухайлбал, 9 болон 11 дүгээр батламжууд нь монгол оролцогчдод хоёрдмол утгаар ойлгогдсон байх боломжтой юм. Мөн судлуулагчдын дотор эмэгтэй оролцогчдын эзлэх хувь (81.5 хувь) харьцангуй өндөр байсан нь түүврийн хэв гажуудлыг үүсгэсэн байж болзошгүй.

Бусад орнуудын туршлагаас харахад (Esbjørn et al., 2015; Kim et al., 2011) CFA-д онолын хоёр хэмжээст загвар дэмжигдэхгүй тохиолдолд соёлд тохирсон хувилбар загварыг санал болгодог. Монголын хувьд ч цаашдын судалгаанд тийм шийдэл санал болгох боломжтой.

Судалгааны хязгаарлалт

Энэхүү судалгааны хүрээнд дараах хязгаарлагдмал талуудыг авч үзэх шаардлагатай. Нэгдүгээрт, түүвэр нь зөвхөн их, дээд сургуулийн оюутнуудаас бүрдсэн тул насанд хүрэгчдийн ерөнхий хүн амыг бүрэн төлөөлөхгүй. Хоёрдугаарт, эмэгтэй оролцогчдын эзлэх хувь (81.5 хувь) өндөр байсан нь хүйсийн тэнцвэрт бус байдлыг үүсгэсэн байх боломжтой. Гуравдугаарт, конвергент болон дискриминант тохирц чанарын шинжилгээ (бусад асуулгатай харьцуулалт) хийгдээгүй нь тохирц чанарын дүр зургийг бүрэн дүгнэхэд хязгаарлагдмал тал болж байна.

ДҮГНЭЛТ

ECR-R арга зүйн монгол хувилбар нь баталгаат чанарын хувьд маш өндөр үзүүлэлттэй (α=.950; ICC>.92) бөгөөд агуулгын тохирц чанар (CVI=0.88) хүлээн зөвшөөрөгдөх хязгаарыг хангасан байна. Гэсэн хэдий ч баталгаажуулах хүчин зүйлийн шинжилгээний үр дүнд онолын хоёр хэмжээст загвар хангалттай тохирцтой гарсангүй (хамгийн сайн загварын CFI=0.816, RMSEA=0.086). EFA-аар гурван хүчин зүйлт бүтэц илэрсэн нь эсрэг утгатай батламжуудын хэлбэржилтийн нөлөөг тусгасан бифактор загвар болон соёлд тохирсон хувилбар загварыг цаашид судлах хэрэгцээг харуулж байна.

Цаашдын судалгаанд 1. эрэгтэй оролцогчдын эзлэх хувийг нэмэгдүүлж, насанд хүрэгчдийн олон төрлийн бүлгийг хамруулах; 2. хөндлөн баталгаажуулалт хийх; 3. эсрэг утгатай батламжуудын нөлөөг тусгасан бифактор болон арга зүйн хүчин зүйлтэй загваруудыг шалгах; 4. конвергент болон дискриминант тохирц чанарыг бусад хэрэгсэлтэй харьцуулах замаар үнэлэх хэрэгцээтэй байна.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгаанд сайн дурааараа оролцож, үнэтэй хувь нэмэр оруулсан нийт оролцогчдод чин сэтгэлийн талархал илэрхийлье. Мөн судалгааг зохион байгуулах, мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлсэн сургуулиудын удирдлага, багш нарт гүн талархал дэвшүүлж байна. Түүнчлэн асуулгыг орчуулах, хэл найруулга болон агуулгын үнэлгээ хийх үйл явцад оролцсон сэтгэл судлаач, хэл шинжээч болон бусад мэргэжилтнүүдэд талархал илэрхийлье.

САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭГДЭЛ

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, олон улсын байгууллага, эрдэм шинжилгээний сан, төсөл хөтөлбөрөөс ямар нэгэн санхүүгийн дэмжлэг, тэтгэлэг, санхүүжилт аваагүй болно.

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО

Онолын үндэс, санаа: Н.Н; Арга зүй: Ц.Б; Мэдээлэл цуглуулалт: Н.Н; Өгөгдлийн шинжилгээ: Н.Н; Үр дүнгийн тайлбар: Н.Н; Бичилт (эхний хувилбар): Н.Н; Бичилт (засвар): Н.Н., Ц.Б; Мэргэжлийн удирдлага**:** Ц.Б. Зохиогчид өгүүллийн эцсийн хувилбарыг хянаж, хэвлүүлэхийг зөвшөөрсөн болно.

НОМ ЗҮЙ

Alonso-Arbiol, I., Balluerka, N., Shaver, P., & Gillath, O. (2008). Psychometric properties of the Spanish and American versions of the ECR adult attachment questionnaire. *European Journal of Psychological Assessment, 24*(1), 9-13. https://doi.org/10.1027/1015-5759.24.1.9

Bat-Erdene, E., Tumurbaatar, E., Tumur-Ochir, G., Jamiyandorj, O., Jadamba, T., Yamamoto, E., Hamajima, N., Oka, T., & Lkhagvasuren, B. (2023). Validation of the abbreviated version of the World Health Organization Quality of Life in Mongolia: A population-based cross-sectional study among adults in Ulaanbaatar. *Nagoya Journal of Medical Science, 85*(1), 79-92. https://doi.org/10.18999/nagjms.85.1.79

Bowlby, J. (1979). *The making & breaking of affectional bonds*. Routledge.

Brennan, K. A., Clark, C. L., & Shaver, P. R. (1998). Self-report measurement of adult attachment: An integrative overview. In J. A. Simpson & W. S. Rholes (Eds.), *Attachment theory and close relationships* (pp. 46-76). Guilford Press.

Bretherton, I. (1985). Attachment theory: Retrospect and prospect. *Monographs of the Society for Research in Child Development, 50*(1–2), 3-35. https://doi.org/10.2307/3333824

Bujang, M. A., Omar, E. D., Foo, D. H. P., & Hon, Y. K. (2024). Sample size determination for conducting a pilot study to assess reliability of a questionnaire. *Restorative Dentistry & Endodontics, 49*(1), e3. https://doi.org/10.5395/RDE.2024.49.E3

Busonera, A., Martini, P. S., Santona, A., & Zavattini, G. C. (2014). Psychometric properties of an Italian version of the Experiences in Close Relationships-Revised (ECR-R) scale. *Psychological Reports, 114*(3), 785-801. https://doi.org/10.2466/03.21.PR0.114k23w9

Dupont, K., Gervai, J., Danis, I., Toth, I., Koren, R., & Torok, S. (2022). Factor structure, psychometric properties, and validation of the Hungarian version of the Experiences in Close Relationships Revised (ECR-R-HU) questionnaire in a nationally representative community sample. *Journal of Personality Assessment, 104*(6), 747-758. https://doi.org/10.1080/00223891.2021.2019054

Esbjørn, B. H., Breinholst, S., Niclasen, J., Skovgaard, L. F., & Lange, K. (2015). Identifying the best-fitting factor structure of the Experience of Close Relations-Revised in a Scandinavian example. *PLOS ONE, 10*(9), e0137218. https://doi.org/10.1371/journal.pone.0137218

Fraley, R. C., & Shaver, P. R. (2000). Adult romantic attachment: Theoretical developments, emerging controversies, and unanswered questions. *Review of General Psychology, 4*(2), 132-154. https://doi.org/10.1037/1089-2680.4.2.132

Fraley, R. C., Waller, N. G., & Brennan, K. A. (2000). An item response theory analysis of self-report measures of adult attachment. *Journal of Personality and Social Psychology, 78*(2), 350-365. https://doi.org/10.1037/0022-3514.78.2.350

Hayee, A. A., & Kamal, A. (2023). Experiences in Close Relationships-Revised: Urdu translation and validation for Pakistani married adults. *Journal of Development and Social Sciences, 4*(3), 768-780. https://doi.org/10.47205/jdss.2023(4-III)71

Hazan, C., & Shaver, P. (1987). Romantic love conceptualized as an attachment process. *Journal of Personality and Social Psychology, 52*(3), 511-524.

Jones, J. A., Cassidy, J., & Shaver, P. (2015). Adult attachment style and parenting. In *Attachment theory and research: New directions and emerging themes*. Guilford Publications.

Kim, S.-H., Sherry, A. R., Lee, Y.-S., & Kim, C.-D. (2011). Psychometric properties of a translated Korean adult attachment measure. *Measurement and Evaluation in Counseling and Development, 44*(3), 135-150. https://doi.org/10.1177/0748175611409842

Kooiman, C., Klaassens, E., van Heloma Lugt, J. Q., & Kamperman, A. (2012). Psychometrics and validity of the Dutch Experiences in Close Relationships-Revised (ECR-R) in an outpatient mental health sample. *Journal of Personality Assessment, 95*(2), 217-224. https://doi.org/10.1080/00223891.2012.740540

Kumar, R. M. (2022). Assessing the psychometric properties of Hindi version of Experiences in Close Relationships-Revised (ECR-R) scale. *Indian Journal of Forensic Medicine and Toxicology, 16*(4), 402-406. https://doi.org/10.30564/jpr.v3i3.3464

Ravitz, P., Maunder, R., Hunter, J., Sthankiya, B., & Lancee, W. (2010). Adult attachment measures: A 25-year review. *Journal of Psychosomatic Research, 69*(4), 419-432. https://doi.org/10.1016/j.jpsychores.2009.08.006

Tsend, B., Nasanbat, N., Batsukh, E., Sainbat, U., Marsgerel, B., & Bat-Ulzii, N. (2026). Psychometric Properties of the Mongolian Version of the Experiences in Close Relationships-Revised Child Version. *Lavai-International Journal of Education*, *22*(34), 51-64. https://doi.org/10.5564/lavai.v22i34.4598

Tumurbaatar, E., Hiramoto, T., Tumur-Ochir, G., Jargalsaikhan, O., Erkhembayar, R., Jadamba, T., & Lkhagvasuren, B. (2021). Translation, reliability, and structural validity of the Hospital Anxiety and Depression Scale (HADS) in the general population of Mongolia. *Neuroscience Research Notes, 4*(3 Suppl.), 30-39. https://doi.org/10.31117/neuroscirn.v4i3Suppl.101

Tumurbaatar, E., Jargalsaikhan, O., Tumur-Ochir, G., & Belovol, E. (2022). Reliability and validity of the Mongolian version of Affective Touch Questionnaire. *Neuroscience Research Notes, 5*(2), 100. https://doi.org/10.31117/neuroscirn.v5i2.100

Зохиогчдын мэдээлэл

Овог, нэр: Насанбат Номинзул
https://orcid.org/0009-0004-1399-5278
Байгууллагын нэр: ШУА-ийн Тархи, сэтгэл судлалын хүрээлэн
Хаяг: БЗД, 12 дугаар хороо, Жанжин гудамж, Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор, 5 дугаар давхар
Улс: Монгол
e-mail: nominzuln@mas.ac.mn

Овог, нэр: Цэнд Баярмаа
https://orcid.org/0000-0001-7179-0618
Байгууллагын нэр: Монгол Улсын Боловсролын Их Сургууль
Хаяг: СБД, 8 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө, МУБИС Ё байр, 4 дүгээр давхар
Улс: Монгол
e-mail: ts.bayarmaa@msue.edu.mn